# ЖИЛ

# ТУТМЫН

# ТҮҮХ

## ГАДАС БОЛОН ДҮҮРГҮҮДЭД

Нэгжийн нэр

Нэгжийн дугаар

Он

*Энэхүү жил тутмын түүхийг бид дахин хянасан бөгөөд энэ нь нэгжийн үнэн зөв түүхэн баримтыг харуулна.*

Гадас/Дүүргийн ерөнхийлөгчийн гарын үсэг

Гадас/Дүүргийн бичиг хэргийн ажилтны гарын үсэг

***Гадас*** гэсэн үгийг ***дүүрэгт; хэсгийг салбарт; бишопыг салбарын ерөнхийлөгчид*** хамааруулан ойлгоно.

### Зорилго

Гадас болон хэсгийн түүхүүдийг агуулсан Жил Тутмын Түүх нь Их Эзэний Сүмийн талаарх бүх чухал зүйлсийн түүхийг үргэлжлүүлэн бичиж тэмдэглэх түүний үүрэг хариуцлагыг гүйцэтгэхэд тусалдаг. Тэрээр дэлхий даяарх Өөрийн үйлчлэгчиддээ, тэдний үүрэг даалгавар болсон тэмдэглэлийг илгээхийг зааварчилжээ.

### Үүрэг Хариуцлага

Гадасны ерөнхийлөгч нь ач холбогдол бүхий, үнэн зөв Жил Тутмын Түүх жил бүр танилцуулагдаж байгаа эсэхийг мэдэх үүрэг хариуцлагатай. Тэрээр гадасны жилийн түүхийг бэлтгэх мэргэжилтнийг дууддаг. Мөн бишоп болгон хэсгийн жилийн түүхийг бэлтгэх мэргэжилтнийг дууддаг.

### Жил Тутмын Түүхийг Бэлтгэх нь

Гадас ба хэсэг болгоны түүх нь хоёр хэсэгтэй байна:

1. Гадас болон хэсгийн газар зүйн байрлалаарх Сүмийн ажил болон гишүүдийн итгэлийн талаар өгүүлсэн хүүрнэл. Хураангуйлсан энэ өгүүлэл нь тулгарсан бэрхшээл, амжилт ололт, мөн чухал үйл явдал хийгээд уулзалт цуглаануудыг багтаадаг. Мөн гүйцэтгэсэн ёслолууд болон албан тушаалууд дахь өөрчлөлтүүдийг оруулж болно.

   Гадас болон хэсгийн түүхийн мэргэжилтнүүд нь гишүүдийн амьдралд болон Сүмийн нэгжүүдэд итгэлээр өдөөгдсөн үйл явдлыг оруулах хэрэгтэй. Тэд өгүүлэл бичихийн тулд дараах эх сурвалжуудаас авч ***тохиромжтой бол*** доорх зүйлүүдээс иш татах буюу гэрэл зургуудыг оруулж болно:

   - Тэмдэглэл, тайлан буюу дурсамжууд
     - Хурлын тэмлэглэлээс авсан мэдээлэл г.м (эдгээрт гадасны ерөнхийлөгч буюу бишопын зөвшөөрөл шаардлагатай бөгөөд ариун нандин, нууц материалуудыг оруулах ёсгүй)
     - Гадас, хэсэг, чуулга болон хавсралт байгууллагын тайлангууд
     - Захидал харилцаа
     - Гэрэл зураг (тодорхой авсан газар, хүмүүсийн нэрс, өдрийг нь заасан хар цагаан зураг толхиромжтой)
     - Сонины хайчилбарууд (гэрэл зургийн хуулбар байх нь тохиромжтой)

2. Тухайн жилд болсон гадас болон хэсгийн чуулгуудаас дэмжин баталсан Албан Тушаалтнуудын маягтууд.
   - Officers Sustained (Stake) (32300)
   - Дэмжигдэх Албан Тушаалтнууд (Дүүрэг) (32301 363)
   - Officers Sustained (Ward/Branch in Stake) (32302)

### Жил Тутмын Түүхийг Танилцуулах нь

Хэсгийн мэргэжилтнүүд нь жил бүрийн нэгдүгээр сарын 15-наас хэтрүүлэлгүйгээр гадасны түүхийн мэргэжилтэнд түүхийг өгөх ёстой. Гадасны мэргэжилтнүүд нь гадас болон хэсгийн түүхүүдийг жил бүрийн Нэгдүгээр сарын 31-нээс хожимдуулалгүй өгөх ёстой. Цагирагтай хавтас буюу нимгэн гялгар хавтсанд жил тутмын түүхийг хийж өгч болохгүй.

Америкийн Нэгдсэн Улс болон Канад дахь гадасны мэргэжилтнүүд Жил Тутмын Түүхийн хавтсыг дараах хаягаар илгээх ёстой:

CHURCH ARCHIVES
ANNUAL HISTORY
50 E NORTH TEMPLE ST
SALT LAKE CITY UT 84150-3800

Америкийн Нэгдсэн Улс болон Канадаас гаднах гадасны мэргэжилтнүүд Жил Тутмын Түүхийн хавтсыг бүсийн захиргаанд илгэх ёстой.

# Жил Тутмын Түүх

Он

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

(Folder and Instructions for Preparing the Annual History, Mongolian). 3/01. (3/01). 32299 363